

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ


ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

1. Сургалт, судалгаа соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлын хүрээнд :

Байгууллагын ажилтнуудаас ёс зүйн тухай ойлголт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дэд хорооны талаар мэдлэг, мэдээллийг үнэлэх зорилгоор 2 удаа бичгээр судалгаа авч нэгтгэн дүгнэсэн. Судалгаан дээр үндэслэн Монгол улсын ёс зүйн хороонд хандаж, арга зүйн дэмжлэг хүссэний дагуу соён гэгээрүүлэх, сурталчилан таниулах ажлын хүрээнд ёс зүйн тухай ойлголт, ёс зүйн тухай хуулийн талаар сургалт зохион байгуулсан. Сургалтыг Ёс зүйн хорооны ажлын албаны хэлтсийн дарга Ц.Заяхүү хүрэлцэн ирж, таниулах, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулагдсан.



Шинэ ажилтнуудад таниулах, чиглүүлэх сургалтыг 1 удаа, нийт ажилтнуудад ёс зүйн талаар соён гэгээрүүлэх, таниулах сургалтыг 1 удаа, ёс зүйн ойлголт, хэм хэмжээний талаар Монгол улсын засгийн газрын тогтоолыг болон бусад цаг үеийн мэдээллийг тухай бүрд нь ERP чатаар болон бусад хэлбэрээр хүргэж ажилласан.




Ёс зүйн харилцаа хандлагын эерэг төлөвшлийг бий болгох ажлын хүрээнд ажлын эхлэх цагийн хоцролтгүй байнга ажлын эхлэх цагтаа ажлын байрандаа бэлэн байдаг ажилтнуудаа төвийн даргын санаачлагаар урамшуулсан.

Цахим орчинд болон мэдээллийн самбарт 22 удаа мэдээлэл нийтэлж, түгээн ажилласан.



2. Өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байдал:

Ёс зүйн дэд хороонд 5 гомдол ирсэн бөгөөд 4 гомдлыг шалгаж шийдвэрлэн ажиллаж, 1 гомдлыг Нийслэлийн Ёс зүйн дэд хорооруу илгээж праграммд бүртгэсэн.



3. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадахжуулах ажлын хүрээнд:

Ёс зүйн хорооноос жил бүрийн 11 дүгээр сарыг ёс зүйн нөлөөллийн сарын аян болгон зарладаг уламжлалтай. 2025 оны 11 дүгээр сарын ёс зүйн нөлөөллийн аяныг "Хүндэлье, энэрье" нэртэй зарласан. Ёс зүйн нөлөөллийн аяны хүрээнд Ёс зүйн хорооноос хийгдэх зорилтот ажлын нэг нь Удирдлагын академитай хамтран зохион байгуулдаг Ёс зүйн сургагч багш бэлтгэх 2 дахь удаагийн хөтөлбөр юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд ёс зүйн сургагч багшаар суралцах хүсэлтэй төрийн албан хаагчдыг 2025 оны 10 дугаар сарын 13-наас 27-ны өдрүүдэд нээлттэй сонгон шалгаруулалтаар бүртгэсэн. Ёс зүйн сургагч багшаар суралцах хүсэлтээ нийт 277 төрийн албан хаагч Ёс зүйн хороонд ирүүлсэн. Тэднийг сонгон шалгаруулалтаар зарласан. Ажлын хэсэг хянаж, шалгуурыг хангасан 50 төрийн албан хаагчийг шалгаруулсан. Үүнд дэд хорооны гишүүн Б.Буянсүрэн тэнцэж сургалтанд хамрагдаж "Ёс зүйн сургагч багш"-ийн үнэмлэхээ гардан авсан.



Дүгнэлт

2025 онд Ёс зүйн дэд хороо шинээр байгуулагдаж ажиллаж эхэлсэн. Байгууллагын албан хаагчид болон дэд хорооны гишүүд төрийн албан хаагчийн ёс зүй - ёс суртахуунд суралцсан жил болж өнгөрлөө. Цаашид ёс зүй- ёс суртахуунтай төрийн албан хаагчийн манлайллыг өргөжүүлэн соён гэгээрүүлэх, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж дадал болгох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь чухал байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ

Б.ЭНХДӨЛГОР